



БҮРЭН СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУД, ТУСГАЙ САНГУУДЫН 2013 оны САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан

Аймгийн дарга, Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар

Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-9
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	10
• Аудитын санал дүгнэлт	10

**Төв аймгийн Бүрэн сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Бүрэн сумын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн “тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Бүрэн сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 29100.2 мянган төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 22220.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 6880.1 мянган төгрөгөөр дутуу буюу 76.3 хувийн биелэлттэй байна.
- Орон нутгийн орлогын данс эх үүсвэр 1708.3 мянган төгрөгөөр зөрүүтэй .
- Тусгай зориулалтын сангуудын тайланг Засаг дарга гарын үсэг зурж батлагаажуулаагүй, харилцах дансыг боловсруулж журнал туслах хөтлөөгүй
- Нэгтгэсэн тайланд нийт 39085.1 мянган төгрөгийг Сангийн сайдын 2013.12.02-ний өдрийн 269-р тушаалыг зөрчиж Засгийн газрын оруулсан капитал дансыг нэмэгдүүлэн тайлагнаж нэгтгэсэн.
- Хөрөнгийн тооллого хийсэн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт байхгүй

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд Орон нутгийн орлогын болон тусгай зориулалттай сангуудын дансны орлого, зарлага зөрүүтэй, төсөвт байгууллагуудын няравын тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй, хөрөнгийн тооллого тооцоо бодсон акт байхгүй батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй хэтрүүлэн зарцуулсан нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс их тул мөнгөн хөрөнгө болон хөрөнгийн тооллого тооцоо бодолтын хувьд **Хязгаарлалттай санал дүгнэлт** гаргахаар Тэргүүлэх аудитор санал оруулсан байгаа

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.23

Танилцуулга

Бүрэн сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Бүрэн сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Бүрэн сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Бүрэн сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Бүрэн сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Бүрэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012.12.19-ний өдрийн 2-р хуралдааны 02 тоот тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 28300.2 мянган төгрөгөөр баталсан ба аймгаас суутган -2 –оор 800.0 мянган төгрөгөөр тодотгож 29100.2 мянган төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 22220.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 6880.1 мянган төгрөгөөр дутуу буюу 76.3 хувийн биелэлттэй байна. Орлогын төлөвлөгөө тасархад ИОТТХ –ний татварыг 11373.6 мянган төгрөгөөр буюу 46 хувиар тасарсан нь ихээхэн нөлөөлсөн байна

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 6334.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба жилийн эцэст 4251.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн. Үүнд: Төрийн сангийн хуулгаар орон нутгийн төсвийн 142800910 тоот дансанд 4051.9 мянган төгрөг, 142800972 тоот дансанд 200.0 мянган төгрөг байна.

Орон нутгийн төсвийн болон бусад эх үүсвэрийн нэгтгэлийг тулган шалгахад:

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогыг тулган баталгаажуулахад эхний үлдэгдэл 6334.0 мянган төгрөг байсан ба орон нутгийн орлогоор 22220.1 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 240901.9 мянган төгрөг, БХСанд 5430.0 мянган төгрөг, сумын ОНХСангаас 10000.0 мянган төгрөг нийт 284886.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн. Төрийн сангийн шилжүүлгээр ЗДТГазарт 167254.5 мянган төгрөг, ИТХуралд

37395.3 мянган төгрөг, Багт 46142.6 мянган төгрөг нийт 250792.4 мянган төгрөгийн санхүүжилтийг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазар 22220.1 мянган төгрөг, БХСанд 5430.0 мянган төгрөг нийт 278442.5 мянган төгрөг олгосныг хасч тооцоход үлдэгдэл 6443.5 мянган төгрөг байна. Энэ нь харилцах дансны баримтыг боловсруулж үлдэгдлийг тухай бүрт тулгаж байгаагүйгээс Төрийн сангийн үлдэгдлээс $2191.6 \text{ мянган төгрөгөөр}$, аймгаас авсан санхүүжилтээс $/250792.4 - 240901.9 - 10000.0/ = 109.5 \text{ мянган төгрөгөөр}$ зөрүүтэй байна.

Аудитын явцад орлого эх үүсвэрийг залруулах саналыг хүлээн зөвшөөрч ХААН банкны болон Төрийн сангийн хуулгыг дахин боловсруулснаар орон нутгийн дансны оны эхний үлдэгдлээс Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд 3099.9 мянган төгрөг, булгын эх хашсан санхүүжилтийн үлдэгдэлд 800.0 мянган төгрөг бүгд 3899.9 мянган төгрөгийг олгосон зарлага нэмэгдснийг тооцоход эх үүсвэр 1708.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан тул дахин тулган дансыг боловсруулж ирэх үүрэг өгсөн.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 489506.5 мянган төгрөг, Цэцэрлэгт 224507.7 мянган төгрөг, Эмнэлэгт 203559.6 мянган төгрөг, Соёлын төвд 43290.5 мянган төгрөг, нийт 960864.5 мянган төгрөг шилжүүлсэн ба дээрх байгууллагуудын оны эхний үлдэгдэл 7778.2 мянган төгрөг, жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 16853.7 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангийн санхүүжилт 194996.9 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 145591.9 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 42640.0 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 4580.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 2185.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 6570.4 мянган төгрөг, Багт 4095.2 мянган төгрөг, Сургууль 2253.8 мянган төгрөг, Цэцэрлэгт 2000.0 мянган төгрөг, ЭМТөв 7500.0 мянган төгрөг, нийт 22419.4 мянган төгрөгийн орлого, 15962.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 6456.9 мянган төгрөгийн үлдэгдлийг нэгтгэсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Соёлын төв 992.0 мянган төгрөг, ЭМТөв 379.5 мянган төгрөг нийт 1371.5 мянган төгрөг нэгтгэгдсэн ба Тамгын газрын ОНИМТөвийн үйлчилгээний орлого 101.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрснийг татварын орлогоор нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 60000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд Улсын төсвийн байгууллагын үлдэгдэл 7778.4 мянган төгрөг, Орон нутгийн байгууллагын 1604.9 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 89762.6 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 6334.0 мянган төгрөг, нийт 105480.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. БХСангийн ХААН банкны 5737001171 тоот дансны оны эхний үлдэгдэл 5011374 төгрөгийг Санхүүгийн тайланд залруулах санал болгосон боловч залруулж ирээгүй ба сумын нэгтгэсэн тайланд эхний үлдэгдлийг нэгтгэсэн.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 38144.3 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 4251.9 мянган төгрөг, ЭМТөвийн нэмэлт дансны үлдэгдэл 2361.7 мянган төгрөг, Багийн нэмэлт дансны үлдэгдэл 4095.2 мянган төгрөг нийт 48853.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаар болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн

баталгаатай тохирч байна. Багийн нэмэлт санхүүжилтийн дансны харилцах дансны үлдэгдлийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байгааг залруулах

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 92769.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 217565.5 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 200665.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 109669.8 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. ЗДТГазар нь санхүүгийн тайланд бараа материалын тайлангийн нүүрсний няравын тайлангаас 2100.0 мянган төгрөгийг илүү тайлагнасан байсныг залруулсныг сумын нэгтгэсэн тайланд аудитын явцад залруулсан.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 3454716.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 231668.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 14429.8 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 3671954.7 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 83721.8 мянган төгрөг үлдэх өртөг 2233086.8 мянган төгрөг байна. Сургууль 32133.5 мянган төгрөг, Цэцэрлэг 5982.3 мянган төгрөг, Соёлын төв 969.4 мянган төгрөг нийт 39085.1 мянган төгрөгийг Сангийн сайдын 2013.12.02-ний өдрийн 269-р тушаалыг зөрчиж Засгийн газрын оруулсан капитал дансыг нэмэгдүүлэн тайлагнаж нэгтгэсэн байна.

Авлага, өглөг

Сумын нэгдсэн тайлангаар Авлага Оны эхэнд 66477.5 мянган төгрөгийн авлага, оны эцэст 219949.5 мянган төгрөг оны эцсийн авлагын 219540.4 мянган төгрөг буюу 99.8 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд 6126.8 оны эцэст 14597.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн ба ЭМТөвийн залруулсан тайлангаар тайлагнасан 2361.7 мянган төгрөгийн өглөгийг дутуу нэгтгэсэн байна.

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байна. Тусгай зориулалтын сангуудын тайланг Засаг дарга гарын үсэг зурж батлагаажуулаагүй байсан ба гарын үсэг зуруулж авчирч өгсөн байна. Сангуудыг тодруулахад:

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн Хөгжлийн санд 161616.5 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн төсвөөс авсан байна. Үүнээс 131520.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст харилцах дансандаа 30096.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Үлдэгдэл Төрийн сангийн үлдэгдлээс 10 төгрөгөөр зөрүүтэй байна. Харилцах дансны баримтыг боловруулаагүйгээр санхүүгийн тайланг орлого зарлагаар эхсэл файлаар бөглөсөн. Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангаар 131520.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн ба Төрийн сангийн ОНХСангийн 142852400 тоот дансны зарлагын гүйлгээний жагсаалтаар 139860.3 мянган төгрөг хийгдсэн **зөрүү 8340.0** мянган төгрөг байна. Төрийн сангийн бүртгэлийн дансны хуулгыг 2013.04.01-2013.12.10-ний байдлаар гаргаж баримтанд үдэж хавсаргасан 31-ээр хуулгыг аваагүй байна. 2013.12.10-ний өдрийн хяналтын түвшний хуулгаар 109956.5 мянган төгрөгийн орлого, 107495.7 мянган төгрөгийн зарлага хийгдэж үлдэгдэл 2460.8 мянган төгрөг байсан байна.

Төрийн сангийн нэгдсэн сүлжээнд 2013.04.23-наас эхэлж шилжсэн оны эхний 4 сарын хуулгыг ХААН банкнаас аваагүй. Ня-бо-гч ХААН банкинд гүйлгээ хийгдээгүй гэх боловч ОНХСангийн баримтанд ХААН банкаар 5737001228 тоот дансаар хийгдсэн төлбөрийн даалгавар үдээтэй байна. Үүнд: 2013.04.15-нд Т.Мөнхочирт тоглоомын талбайн материал татсан тээврийн хөлс гэж 1.0 сая төгрөг, 2013.04.12-нд Д.Отгонбаярт тоглоомын талбайн хашааны төмөр гэж 4.0 сая төгрөг, 2013.04.12-нд Ц.Мэндбаярт тоглоомын талбайн хашааны тоосго гэж 1440.0 мянган төгрөг, 2013.04.12-нд Б.Баатарт тоглоомын талбайн хашааны цемент гэж 780.0 мянган төгрөг гэх мэтээр шилжүүлсэн байна.

Тус сум нь тайлант онд 217000.0 мянган төгрөгийн 12 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс гүйцэтгэлээр 131520.3 мянган төгрөгийг олгосон байна. Эдгээр төсөл хөтөлбөрөөс 10 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж 121520.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжээгүй нь 3 багт хадлангийн боогч 12500.0 мянган төгрөгөөр, 4 айлын орон сууц барихад 40000.0 мянган төгрөг гэсэн 2 төсөл хөтөлбөр хэрэгжээгүй ба аймгийн ЗДТГазарт 10000.0 мянган төгрөгийг шилжүүлж зарцуулсан. **Шийдвэр асуух** шийдвэр байхгүй

Тайлант онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрөөс Хүүхдийн тоглоомын талбай 15.0 сая төгрөг, ЗДТГазрын граж 15.0 сая төгрөг, Гэрэлтүүлэг 10.0 сая төгрөг, баяр наадам 5.0 сая төгрөг, хогний хашаа 2,5 сая төгрөг, монтрак групп тракторыг 42.2 сая төгрөг, сумын өндөрлөг 4.0 мянган төгрөг, сумын төвийн худаг засвар 12845.1 мянган төгрөг, хужирын харуулын байрны хашаа 14.4 сая төгрөг бэлтгэснийг ЗДТГазрын үндсэн хөрөнгөнд бөөн орлогын баримт бичиж орлогодсон. Дээрх хөрөнгийг хүлээн авсан акт үндсэн нэг ширхэг ч баримт байхгүй байна. ОНХСанд худалдан авах ажиллагаа явуулаагүй төсөл хөтөлбөр арга хэмжээний зураг төсөв, судалгаа байхгүй зэрэг зөрчлүүд байгаа тул Гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

ГХУССангийн талаар:

Тус сангийн санхүүгийн байдлын тайланд харилцах дансны эхний үлдэгдэл 737.0 мянган төгрөг, оны эцэст 0.2 мянган төгрөг, Мөнгөн гүйлгээний тайлангаар 1382.9 мянган төгрөгийн орлого, 2119.7 мянган төгрөгийн зарлага хийгдсэн байна. ГХУССангийн дансны хуулгаар ИТХурлаас 1212.9 мянган төгрөгийн санхүүжилт, актын төлбөр 170.0 мянган төгрөг нийт 1382.9 мянган төгрөг орж, үйл ажиллагааны зардалд 2119.7 мянган төгрөгийг зарцуулсан гэж боловсруулсан байна.

Тайлант онд ИТХурлын гэмт хэргийн урьдчилан сэргийлэх зардлаас 1212.9 мянган төгрөгийн орлого төвлөрсөн тохирч байна. Авлага, өглөг бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Мал хамгаалах сангийн талаар:

МХСангийн санхүүгийн байдлын тайлангаар оны эхний үлдэгдэл 9082.6 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнаагүй байна. ХААН банкинд мал хамгаалах сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 9082.6 мянган төгрөг байсан ба эхний 3 сард өвсний орлого 1524.5 мянган төгрөг, зарлага 4249.8 мянган төгрөг, 4-р сард өвсний орлого 80.0 мянган төгрөг, зарлага 241.5 мянган төгрөг Төрийн санд 180.0 мянган төгрөгийн орлого, зарлага 6343.1 мянган төгрөг тайлант онд нийт 2056.5 мянган төгрөг төвлөрч 11584.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн үлдэгдэл $9082.6 + 1784.5 - 10834.4 = 32.7$ мянган төгрөг байна. Үүнд:

Авлага: Алаг түрүү ХХК-д өвсний үнэ 2500.0 мянган төгрөг, Ширээбазарт 2822.5 мянган төгрөг шилжүүлсэн авлагаар тайлагнаагүй ба Өвс тэжээл бэлтгэсэн тайлан байхгүй байна.

Санхүүгийн байдлын тайлангаар хангамжийн материал 3418.0 мянган төгрөг тайлагнасан ба нэгтгэсэн тайланд орхигдуулсан байна

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сангийн эхний үлдэгдэл 72466.5 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд тайлагнаагүй 0 төгрөг гэж тайлагнасан.

СХСангийн харилцах данс нь ХААН банкинд 5737090402 тоот данстай байсан ба Төрийн сангийн нэгдсэн сүлжээнд ороход ХААН банкинаас 61801545 төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.

2013.01.08-нд 5 багт баг тус бүрт 1.0 сая төгрөг ба 4.0 сая төгрөгийг олгосон. 2012 оны 12-р сард 1 баг нь 1.0 сая төгрөгийг нийт 5.0 сая төгрөгийг Баг хөгжлийн сан гэж байгуулахад олгосон. 2013 оны 12-р сард 4095.2 мянган төгрөгийг Багийн нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Авлага Санхүүгийн тайланд оны эхний болон эцсийн авлагыг тайлагнаагүй байна.

Аудитын явцад авлагыг 219540.4 мянган төгрөгийг залруулан тайлагнасныг нэгтгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний 117235.5 мянган төгрөгийн орлого, 189504.0 мянган төгрөгийн зарлагыг тайлагнаж оны эцэст 198.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Гүйлгээг үндсэн баримтаас тулган шалгахад ХААН банкны харилцах дансаар 69535.0 мянган төгрөг, үүний 60000.0 мянган төгрөг нь аймгийн ХЭДСангаас олгосон зээлийн санхүүжилт төвлөрсөн байна. Төрийн сангийн дансаар $111502.0 - 61801.5 = 49700.5$ мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Нийт орлого $69535.0 + 49700.5 = 119235.5$ мянган төгрөг зөрүү 2000.0 мянган төгрөг байна.

Зарлагын гүйлгээ ХААН банкинаас $142001.5 - 61801.5 - 200.0 = 80000.0$ мянган төгрөгийг 12 хүнд зээл олгосон. Төрийн сангийн харилцах данснаас $111304.0 - 109304.0 = 2000.0$ мянган төгрөг зөрүү ба 109304.0 мянган төгрөгийг 24 иргэнд зээл олгосон байна 2000.0 мянган төгрөгийн зөрүү нь Х.Өрнөхийн зээл эргэж орсныг буцааж төвлөрүүлсэн байна. Х.Өрнөхийн зээлийн гэрээнд гэрээний талууд гарын үсэг зураагүй 2 хувийг үдсэн байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Уг санд БХСанг нэгтгэсэн байна

БОНССангийн санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэд байхгүй оны эцэст 3706.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд 14226.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, 10520.0 мянган төгрөгийн зарлага гарч 3706.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Аудитын явцад орлогын үндсэн баримтаас тодруулахад аймгийн төсвөөс 5430.0 мянган төгрөгийн санхүүжилт өгснийг тайланд тусгаагүй байна. Энэ нь нягтлан бодогчийн БОНССангийн 2013 оны хуулга боловсруулсан баримтаар нөхөн сэргээлтээр 14220.0 мянган төгрөг, БХСангийн үлдэгдэл 6.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

БХСангийн ХААН банкны 5737001171 тоот дансны оны эхний үлдэгдэл 5011374 төгрөг, орлогын 912.4 мянган төгрөг, зарлагын 5916.8 мянган төгрөгийг орхигдуулан тайлагнаж нэгтгэсэн байна.

Хог хаягдал сангийн ХААН банкны 5737090887 тоот дансны оны эхний үлдэгдэл 140.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна. Санхүүгийн тайланд залруулах санал болгосон боловч залруулж ирээгүй ба сумын нэгтгэсэн тайланд эхний үлдэгдлийг нэгтгэсэн.

Зарлагын гүйлгээгээр 2013.01.22-нд 3000.0 мянган төгрөгийг орон нутагт шилжүүлэв гэснийг тодруулах Төрийн сангийн төлөөлөгчийн тайлбараар БХСангаас БОНССанд 2013.01.21-нд шилжүүлээд эргүүлж 2013.01.22-нд БХСанд шилүүлсэн байна. БХСан БОНССангуудыг нэгтгэсэн тул эргүүлж шилжүүлсэн гүйлгээ нягтлан шалгах гэсэн боловч нотлох ямар баримт байхгүй өөрөөр хэлбэл санхүүгийн тайланд зарлагаар тайлагнагдсан тул

тодруулж ирүүлэхээр албан шаардлага бичлээ. 2013.02.06-ний өдөр 2602.0 мянган төгрөгийг, 2013.02.22-ний өдрийн 360.0 мянган төгрөгийг нийт 2962.0 мянган төгрөгийг касст бэлнээр авсан ба эд хариуцагч нь 2311.8 мянган төгрөгийг бэлэн мөнгөний гүйлгээний тайланд тайлагнасан ба 650.2 мянган төгрөгийн тайлан үндсэн баримт байхгүй тул төлбөрийн акт бичлээ.

Нягтлан бодогч тайлбарлахдаа аймгаас ирсэн 5430.0 мянган төгрөгийг орлогот хог хаягдал хашаа тохижуулахад 4430.0 мянган төгрөг, нуурын мэдээллийн самбар 400.0 мянган төгрөг, замын тэмдэг 300.0 мянган төгрөг, хогийн сав 260.0 мянган төгрөг, самбарын гагнуур 40.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2013.12.25-нд ямар ч үндсэн баримтгүй гүйлгээний утга зарлага гэж 180.0 мянган төгрөгийг ХААН банкны 5737001228 тоот дансанд шилжүүлсэн кассын баримт үзүүлэх Дээрх хөрөнгүүдийн орлого байхгүй хийгдээгүй байгаад акт бичих

Төрийн сангийн үлдэгдлийн баталгаа ирүүлээгүй байна.

Эм эргэлтийн сангийн талаар:

Эм эргэлтийн сангийн харилцах данс ХААН банкинд байршиж гүйлгээ хийгддэг. Тус сан нь оны эхэнд 2465.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 4110.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Баримт нь ЭМТөвийн тайлантай хамт шалгагдсан болно.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд илэрсэн 268393.5 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **Хязгаарлалттай** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын газар

2014.03.21